

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Цант Орхон" ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/19/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.selenge@audit.gov.mn

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК

Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	13
4. Аудитын тайлан.....	14
4.1. Ерөнхий зүйл.....	14
4.2. Материаллаг байдал.....	14
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	165
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулга.....	16
5.1 Албан шаардлага.....	17
5.2 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МТА	Монголын татварын алба
МУЕА	Монгод улсын ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НД	Нийгмийн даатгал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ЦАНТ ОРХОН” ААТҮГ-ЫН
ДАРГА Д.БАТЭРДЭНЭ
ТАНАА

2025-03-15 № ЦОА-2025/19/НА-СТА-010941
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Цант Орхон” ААТҮГ нь тайлант онд 1,313,787.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,521,746.6 мянган төгрөгийн зардал гарган, 207,959.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдал нь үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр бус үлдэх өртөгтэй хөрөнгө акталж үндсэн хөрөнгийн гарз үүсснээс голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Бараа материал худалдан авах, цалин хөлс олгох зэрэг зардлын гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэж байгаа нь мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	432,066,332.47	333,054,080.66
1.1.2	Дансны авлага	40,138,552.01	12,493,518.45
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		1,333,756.98
1.1.4	Бараа материал	78,366,346.24	101,333,421.48
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	550,571,230.72	448,214,777.57
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,882,979,328.54	9,502,964,510.13
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,882,979,328.54	9,502,964,510.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,433,550,559.26	9,951,179,287.70
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	297,897.76	4,641,023.40
2.1.1.1	Татварын өр	297,897.76	4,641,023.40
2.1.1.3	Богино хугацаат өр төлбөрийн дүн	297,897.76	4,641,023.40
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	297,897.76	4,641,023.40
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,937,114,135.00	1,893,696,135.00
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,574,144,861.64	9,235,812,230.39
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	-	58,300,000.00
2.3.4	Хуримтлагдсан ашиг	(1,078,006,335.14)	(1,241,270,101.09)
2.3.5	Эздийн өмчийн дүн	15,433,252,661.50	9,946,538,264.30
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,433,550,559.26	9,951,179,287.70

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,129,352,539.75	1,264,290,141.74
2	Борлуулалтын өртөг	1,277,667,364.25	1,335,422,903.44
3	Нийт ашиг (алдагдал)	(148,314,824.50)	(71,132,761.70)
4	Түрээсийн орлого	9,456,363.65	12,410,909.05
5	Хүүний орлого	5,883,213.82	5,087,461.60
6	Бусад орлого	10,099,901.55	31,998,826.62
7	Борлуулалт маркетингийн зардал		
8	Ерөнхий ба удирдлагын зардал	41,029,793.09	51,161,426.38
9	Санхүүгийн зардал		
10	Бусад зардал	483,209.10	7,381,373.64
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(2,952,356.41)	(127,780,977.22)
12	Бусад ашиг (алдагдал)		
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(167,340,704.08)	(207,959,341.67)
14	Орлогын татварын зардал		
15	Татварын дараах ашиг (алдагдал)	(167,340,704.08)	(207,959,341.67)
16	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
17	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(167,340,704.08)	(207,959,341.67)
18	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
19	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
20	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
21	Бусад олз (гарз)		
22	Орлогын нийт дүн		
23	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,937,114,135.00	14,574,144,861.64	0.00	(910,665,631.00)	15,600,593,365.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	1,937,114,135.00	14,574,144,861.64	0.00	(910,665,631.00)	15,600,593,365.64
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(167,340,704.00)	(167,340,704.00)
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,937,114,135.00	14,574,144,861.64	0.00	(1,988,671,966.00)	14,522,587,030.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				44,695,576.00	44,695,576.00
Залруулсан үлдэгдэл	1,937,114,135.00	14,574,144,861.64	0.00	(1,033,310,759.42)	15,477,948,237.22
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(207,959,341.67)	(207,959,341.67)
Өмчид гарсан өөрчлөлт	(43,418,000.00)		58,300,000.00		14,882,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(5,338,332,631.25)			(5,338,332,631.25)
2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,893,696,135.00	9,235,812,230.39	58,300,000.00	(1,241,270,101.09)	9,946,538,264.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,294,612,398.14	1,470,181,523.76
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,267,656,487.32	1,414,399,553.27
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,006,250.00	3,510,955.00
	Бусад мөнгөн орлого	25,949,660.82	52,271,015.49
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,198,146,279.85	1,343,256,405.57
	Ажиллагчдад төлсөн	486,960,266.05	579,928,325.44
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	142,565,559.65	166,612,293.29
	Бараа материал худалдан авахад төлсөн	260,315,245.00	290,810,090.00
	Ашиглалтын зардалд төлсөн	82,671,877.47	71,367,094.72
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	64,781,300.00	53,925,440.00
	Татварын байгууллагад төлсөн	142,031,981.68	152,009,135.52
	Даатгалын төлбөрт төлсөн	2,275,150.00	2,465,916.60
	Бусад мөнгөн зарлага	16,544,900.00	26,138,110.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	96,466,118.29	126,925,118.19
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(68,924,065.00)	(209,293,050.00)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	68,924,065.00	209,293,050.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(68,924,065.00)	(209,293,050.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		

	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(15,098,560.00)	(16,644,320.00)
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Бусад	(15,098,560.00)	(16,644,320.00)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,098,560.00)	(16,644,320.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,443,493.29	(99,012,251.81)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	419,622,839.18	432,066,332.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	432,066,332.47	333,054,080.66

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгсгөөр/	
			Зөрүү	Хувь
Орлогын нийт дүн	1,176,529,740.00	1,313,787,339.01	(137,257,599.01)	111.7
Цэвэр борлуулалтын дүн	1,176,529,740.00	1,313,787,339.01	(137,257,599.01)	111.7
Цэвэр усны борлуулалт	13,000,000.00	17,637,082.17	(4,637,082.17)	135.7
Бохир усны борлуулалт	985,574,900.00	1,095,083,407.26	(109,508,507.26)	111.1
Халуун усны орлого	82,500,000.00	90,006,848.66	(7,506,848.66)	109.1
Зочид буудлын орлого	69,954,840.00	68,204,621.75	1,750,218.25	97.5
Бусад орлого	25,500,000.00	42,855,379.17	(17,355,379.17)	168.1
Нийт зардлын дүн	1,621,177,713.00	1,521,746,680.68	99,431,032.32	6.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,552,478,193.00	1,335,422,903.44	217,055,289.56	13.9
Ерөнхий удирдлагын зардал	61,399,520.00	51,161,426.38	10,238,093.62	16.6
Үйл ажиллагааны бус зардал	7,300,000.00	135,162,350.86	(127,862,350.86)	
Цэвэр ашиг алдагдал	(444,647,973.00)	(207,959,341.67)	(236,688,631.33)	53.2

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Цант Орхон” ААТҮГ нь “Мандал суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, айл өрхөөс гарсан бохир усыг татан авч Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, технологийн дагуу цэвэршүүлэн байгальд ээлтэйгээр, нийлүүлж, орон нутагтаа бизнесийн бусад үйл ажлаараа бүрэн тогтворжсон чадварлаг хамт олон болно” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

“Цант Орхон” ААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийг цэвэр усаар хангах,
- Аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйл ажиллагаа явуулах,
- Зочид буудал, үсчин гоо сайхан, дулаан гражаар үйлчилж гадаад, дотоод худалдаа эрхлэх,

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчит аж ахуйн нэгж юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Цант Орхон ” ААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хамтын хэлэлцээр зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын ерөнхий тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,*
- *Усны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,*
- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,*
- *Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр өөрчлөлт орсон*

“Цант Орхон” ААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллагын “Дотоод хяналт шалгалт”-ын баг нь төсөв төлөвлөгөө, үйлдвэрлэл хангамж, хүний нөөц, архив бичиг хэрэг, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа болон худалдан авалт, хөрөнгө оруулалтын чиглэлээр 25 ажил хийхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж тайлагнасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Цант Орхон” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Цант Орхон” ААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,482,371.2 мянган төгрөгөөр буюу 64.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Имянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	432,066.3	333,054.1	(99,012.2)
Авлага	40,138.6	13,827.3	(26,311.3)
Бараа материал	78,366.3	101,333.4	22,967.1
Үндсэн хөрөнгө	14,882,979.3	9,502,964.5	(5,380,014.8)
Нийт хөрөнгө	15,433,550.5	9,951,179.3	(5,482,371.2)

Өр төлбөр	297.9	4,641.0	4,343.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,433,252.6	9,946,538.3	(5,486,714.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,433,550.5	9,951,179.3	(5,482,371.2)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 333,054.1 мянган төгрөг болж 99,012.2 мянган төгрөгөөр буурсан нь 1,481,785.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,580,797.5 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 13,827.3 мянган төгрөг болж 26,311.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн 27,645.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулан, шинээр НДШ-ийн 1,333.7 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалсан байна. Дансны авлагын дүнд ААНБ-с авах авлага 4,443.1 мянган төгрөг, айл өрхөөс авах авлага 6,295.4 мянган төгрөг, ажилчдаас авах авлага 1,756.1 мянган төгрөг, НДШ-ийн авлага 1,333.7 мянган төгрөг тус тус тусгагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 101,333.4 мянган төгрөг болж 22,967.1 мянган төгрөгөөр өссөн нь 319,886.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 296,918.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 5,635,146.9 мянган төгрөгөөр буурсан нь дараах ажил гүйлгээнүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 55,337.3 мянган төгрөгийн зочид буудлын барилгын гадна их засвар, 20,800.0 мянган төгрөгийн 2 ширхэг зөөврийн байшин, 10,330.0 мянган төгрөгийн бетон хашаа, 3,700.0 мянган төгрөгийн сүүдрэвч, 27,000.0 мянган төгрөгийн бага оврын ачааны машин, 18,181.8 мянган төгрөгийн гүнийн худаг гаргуулсан,
- 56,544.4 мянган төгрөгийн шугам хоолойн тоног төхөөрөмж, 7,255.4 мянган төгрөгийн компьютер, буйдан, зурагт худалдан авсан,
- Сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 58,300.0 мянган төгрөгийн цэвэр усны автомашин үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 158 дүгээр тогтоолоор 9,787.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 102,070.8 мянган төгрөгийн, 186 дугаар тогтоолоор байцаагчийн дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй дүгнэлт гарсан халуун усны барилга болон шатаж, гэмтэл авснаас засварлах боломжгүй болсон машин зэрэг 117,993.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 130,299.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан,
- Сор үнэлэмж ХХК-иар ариутгах татуурга цэвэрлэх байгууламжид дахин үнэлгээ хийлгэж дансны үнийг 5,660,225.5 мянган төгрөгөөр бууруулсан, 172,627.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,343.1 мянган төгрөг болж нэмэгдсэн нь НӨАТ-ын өр төлбөр 4,312.8 мянган төгрөг, ХХОАТ-ын өр төлбөр 328.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалсан байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь “Цант Орхон” ААТҮГ-ын даргатай гэрээ байгуулж 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,176,529.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,621,177.7 мянган төгрөгөөр, алдагдлыг 444,648.0 мянган төгрөгөөр тооцож баталсан бөгөөд хөрөнгө оруулалтын 9 арга хэмжээнд 213,950.0 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,313,787.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,521,746.6 мянган төгрөгийн зардал гарган, 207,959.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,313,787.3 мянган төгрөг болж төлөвлөгөөг 137,257.6 мянган төгрөг буюу 111.7 хувиар биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,521,746.6 мянган төгрөг болж зардлыг 99,431.0 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар хэмнэсэн байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагаагаар 92,449.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан боловч 127,781.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгө акталж үндсэн хөрөнгийн гарз үүссэн болон тайлант оны үндсэн хөрөнгийн 172,627.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалан 207,959.3 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нүүрс, үртэс, шатахуун, кафены бараа бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад 4 удаа байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл/

№	Худалдан авах бараа	Тендерийн дугаар	Төсөвт өртөг мян.төг	Шууд гэрээ байгуулсан
1	Нүүрс, үртэс	ЦОААТҮГ/20240102005	95,520.0	“Ширхэнцэг арвин хишиг” ХХК
2	Шатахуун	ЦОААТҮГ/20240202006	66,015.2	“Шунхлай Петролиум” ХХК
3	Бага оврын ачааны машин	ЦОААТҮГ/20240202012	30,000.0	“Цаст хан хөхий” ХХК

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт 4 удаа зарлаж, шатахуун худалдан авахад гүйцэтгэгчээр шалгарсан “Шунхлай петролиум” ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 22-ний өдөр, нүүрс, үртэс худалдан авахад гүйцэтгэгчээр шалгарсан “Ширхэнцэг арвин хишиг” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 17-ний өдөр, бага оврын ачааны машин худалдан авахад гүйцэтгэгчээр шалгарсан “Цаст хан хөхий” ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр тус тус гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд татварын тодорхойлолтоор татварын төрөл бүрээр илүү төлөлттэй байгааг хянаж, татварын байгууллагатай тооцоо хийж үлдэгдлийг залруулах, өмнөх оны шийдвэрээр тайлант онд хөрөнгийг данс бүртгэлээс хассан зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Цант Орхон” ААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,154,792.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,547.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Цант Орхон” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Байгууллагад бүртгэлтэй суудлын автомашиныг шугам хоолойн эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээнээс өөр хэрэгцээнд ашиглахгүй талаар журам боловсруулж мөрдсөн,*
- *Ажилчдад олгодог нормын хувцаснаас өөрөөр бусад дүрэмт хувцсаар жигдрэх явдлыг зогсоосон,*
- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*
- *Удирдлагын гар утасны төлбөрийг байгууллагаас төлөхийг зогсоосон,*
- *Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан гэх мэт.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 19 төрлийн 157 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 174 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 25,145.3 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 75.0 хувийн биелэлттэй байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	10,422.2	2	10,422.2	100.0
Зөвлөмж	2	14,723.1	1	14,723.1	50.0
Нийт дүн	4	25,145.3	3	25,145.3	75.0

Өмнөх аудитаар өгсөн татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулан, авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах **436,520.9** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Төрийн өмчийн дүнг 43,418.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
2. Дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 323,170.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
3. Нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 1,333.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй,
4. Шагнал, тэтгэмж урамшууллын зардлаас суутгасан 328.2 мянган төгрөгийг татварын албанд тайлагнаагүй, татварын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй,
5. НӨАТ-ын төлөлт 5,470.9 мянган төгрөгийг зардлаар бүртгэсэн,

6. Орлогын дэлгэрэнгүй тайланд тусгасан нийт орлогыг татварын цахим системд 371.5 мянган төгрөгөөр дутуу илгээсэн,
7. Мөнгөн гүйлгээний тайланд нийт орлогыг 29,825.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалд төлсөн мөнгийг 12,600.0 мянган төгрөгөөр, нийт 42,425.4 мянган төгрөгөөр дутуу, Нийгмийн даатгалаас орж ирсэн мөнгийг 135.2 мянган төгрөгөөр, татварт төлсөн мөнгийг 7,307.6 мянган төгрөгөөр, гарт олгосон цалинг 12,559.9 мянган төгрөгөөр, нийт 20,002.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д *“аж ахуйн бүх ажил, гүйлгээ”*, 14.4.3-т *“бүх өр төлбөр”*, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 5.1, 17.4-д заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 6,613.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1.Тайлант онд 5,232.3 мянган төгрөгийн шатахуун, материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 13.7 дахь *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо, хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана.”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн цахим баримт буюу анхан шатны баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

2.Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс “Байгууллагын татварын тодорхойлолт”-оор татварын төрөл тус бүрээр 1,381.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гэсэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар

баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой

1.1 Илрүүлэлт: Бараа материал худалдан авах, цалин хөлс олгох зэрэг зардлын гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэж байгаа нь мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа ажил үйлчилгээний төлбөр тооцоо, цалин хөлсний гүйлгээг харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн өмчийн дүнг нэмэгдүүлсэн	1	43,418.0			1	43,418.0	1	43,418.0				
Дахин үнэлгээний нэмэгдэл дансыг илүү тайлагнасан	1	323,170.4			1	323,170.4	1	323,170.4				
НДШ-ийн авлага тусгаагүй	1	1,333.8	1	1,333.8			1	1,333.8				
НӨАТ-ын төлөлтийг зардалд бүртгэсэн	1	5,470.9			1	5,470.9	1	5,470.9				
Хувь хүнээс суутгасан татвар тайлагнаагүй	2	328.2	2	328.2			2	328.2				
НӨАТ-ын тайланд орлого дутуу тусгасан	1	371.5	1	371.5			1	371.5				
Мөнгөн гүйлгээний тайланд орлого зарлагыг илүү, дутуу тайлагнасан	5	62,428.1			5	62,428.1	5	62,428.1				
Дүн	12	436,520.9	4	2,033.5	8	434,487.4	12	436,520.9				

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй	1	1,381.0			1	1,381.0						
Анхан шатны бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан	1	5,232.3			1	5,232.3						
Харилцах дансаар дамжуулан төлбөр тооцоо гүйцэтгэж байх	1						1					
Дүн	3	6,613.3			2	6,613.3	1					